

**“УЛААНБААТАР ЛИФТ” НӨҮГ-ЫН
2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН**

УЛААНБААТАР ХОТ

2023 он

АГУУЛГА

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. “БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН”

- 1.1. Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Эдийн засаг, нийгмийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан үйл ажиллагааны хэрэгжилт 4

ХОЁРДУГААР БҮЛЭГ. “ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН”

- 2.1. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн “Журамд өөрчлөлт оруулах тухай” 491 дүгээр тогтоолын хэрэгжилт 5
- 2.2. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 488 дугаар тогтоолын хэрэгжилт 5
- 2.3. Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн “2023-2024 оныг авлигатай тэмцэх жил болгон зарлах тухай” 49 дүгээр тогтоолын хэрэгжилт 5
- 2.4. Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” 301 дугаар тогтоолын хэрэгжилт 6
- 2.5. Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 442 дугаар тогтоолын хэрэгжилт 6
- 2.6. Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн “Шил ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилт 6
- 2.7. Засгийн газрын 23 дугаар хуралдаанаар “Шил ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” авч хэлэлцсэнтэй холбогдуулан гаргасан хуралдааны тэмдэглэлийн хэрэгжилт 7
- 2.8. Нийслэлийн Засаг даргын “Төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” 2023 оны А/32 дугаар захирамжийн хэрэгжилт 7
- 2.9. Нийслэлийн Засаг даргын “Төсвийн хуваарь батлах тухай” 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн А/47 дугаар захирамжийн хэрэгжилт 8
- 2.10. Нийслэлийн Засаг даргын “Захиалагчийн хяналт тавих тухай” 2023 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн А/101 дүгээр захирамжийн хэрэгжилт 8
- 2.11. Нийслэлийн Засаг даргын 2023 оны “Эрх шилжүүлэх тухай” А/200 дугаар захирамжийн хэрэгжилт 9
- 2.12. Нийслэлийн Засаг даргын " Хууль, норм, дүрэм, стандартын хэрэгжилтийг хангуулах талаар авах зарим арга хэмжээний тухай" 9

“Улаанбаатар лифт” НӨҮГ-ын 2023 оны үйл ажиллагааны жилийн эцсийн тайлан

2023 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн А/242 дугаар захирамжийн хэрэгжилт

- | | | |
|-------|--|----|
| 2.13. | Нийслэлийн Засаг даргын "Стратегийн команд штабын сургууль зохион байгуулах тухай" 2023 оны А/194 дүгээр захирамжийн хэрэгжилт | 9 |
| 2.14. | Нийслэлийн Засаг даргын "Журам батлах тухай" 2023 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн А/1133 дугаар захирамжийн хэрэгжилт | 10 |
| 2.15. | Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 06 дугаар хуралдааны тэмдэглэлийн хэрэгжилт | 10 |
| 2.16. | Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2023 оны жилийн эцсийн хэрэгжилтийн дүн | 10 |

ГУРАВДУГААР БҮЛЭГ. “БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН”

- | | | |
|------|---|----|
| 3.1. | Байгууллагын дүрмээр хүлээсэн үндсэн үүргийн хэрэгжилт | 11 |
| 3.2. | Байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн дотоод ажил үйлчилгээний хэрэгжилт | 18 |
| 3.3. | Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилт | 19 |
| 3.4. | Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлттэй холбоотой мэдээлэл | 21 |
| 3.5. | Байгууллагын 2023 онд гаргасан тайлан, мэдээний тухай мэдээлэл | 22 |

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. “БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ

- | | | |
|------|---|----|
| 4.1. | Байгууллагын ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилттэй холбоотой мэдээлэл | 22 |
|------|---|----|

ТАВДУГААР БҮЛЭГ. “БУСАД МЭДЭЭЛЭЛ”

- | | | |
|------|---|----|
| 5.1. | Байгууллагын харьяа нэгжүүдийн үндсэн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ажилласан тухай мэдээлэл | 26 |
| 5.2. | Бусад үйл ажиллагаа | 26 |

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. “БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН”

1.1. Бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулж, холбогдох газарт тайлагнан ажилласан байна.

- Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Эдийн засаг, нийгмийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тус бүр 1 арга хэмжээ тусгагдсан ба хэрэгжилт 90 хувийн гүйцэтгэлтэй байна. Тус хөтөлбөрийн 6.1.10-д “Нийтийн зориулалттай орон сууцны цахилгаан шат, дээвэр, фасад, инженерийн шугам сүлжээг өргөтгөн шинэчилж иргэдийн ая тухтай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ”, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 9.8.3-д “Нийтийн зориулалттай орон сууцны барилгын ашиглалтын шаардлага хангахгүй цахилгаан шатыг шинэчилсэн байна” гэсэн арга хэмжээний хэрэгжилт 90 хувийн гүйцэтгэлтэй байна.

1.1.1. Улс орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинэчлэгдэж буй лифтний зураг төсөв боловсруулах, захиалагчийн хяналт хийх ажлыг зохион байгуулна.

а. Нийслэлийн төсөв, нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2022-2023 он дамжин хэрэгжсэн нийтийн зориулалттай орон сууцны барилгын 20 цахилгаан шат шинэчлэлийн ажил 100 хувь бүрэн хэрэгжиж улсын комисст хүлээлгэн өгсөн.



б. Нийслэлийн төсөв, нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2023 онд хэрэгжиж буй нийтийн зориулалттай орон сууцны барилгын 8 цахилгаан шат шинэчлэлийн ажил:

- Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/105 захирамжийн хүрээнд нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинэчлэгдэх 4 цахилгаан шатны шинэчлэлийн ажлыг гүйцэтгэхээр “Оакс экспресс Монголиа” ХХК шалгарч, гэрээний дагуу цахилгаан шатны угсралтын ажил 100 хувь хийгдэж 2023 оны 09 дүгээр сарын 22-ны өдөр улсын комисст хүлээлгэж өгсөн.

“Улаанбаатар лифт” НӨҮГ-ын 2023 оны үйл ажиллагааны жилийн эцсийн тайлан

- Нийслэлийн Засаг даргын А/966 дугаар захирамжийн хүрээнд хэрэгжиж буй Нийтийн зориулалттай орон сууцны 2 цахилгаан шатны шинэчлэлтийн ажлыг “Оакс экспресс Монголиа” ХХК нь 2023 оны 11 дүгээр сарын 02-ны өдрөөс 2024 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэлх хугацаанд гүйцэтгэх гэрээ байгуулж, цахилгаан шатыг захиалсан байна.

- Нийслэлийн Засаг даргын А/966 дугаар захирамжийн хүрээнд хэрэгжиж буй Нийтийн зориулалттай орон сууцны 2 цахилгаан шатны шинэчлэлтийн ажлыг “Фүшили элеватор” ХХК нь 2023 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 2024 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийг хүртэлх хугацаанд гүйцэтгэх гэрээ байгуулж, цахилгаан шатыг захиалсан байна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. “ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН”

2023 оны жилийн эцсийн байдлаар тогтоол шийдвэрийн нийт 26 заалтыг хяналтад аван хэрэгжилтийг ханган ажилласан байна. Монгол Улсын Засгийн газрын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн хэрэгжилтийг тус тус хангах зорилгоор үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан гүйцэтгэлд хяналт тавин ажиллаж, улирал бүр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт тайлагнан ажиллаж байна.

2023 оны жилийн эцсийн байдлаар тогтоол шийдвэрийн нийт 26 заалтыг хяналтад аван хэрэгжилтийг ханган ажилласан байна. Монгол Улсын Засгийн газрын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн хэрэгжилтийг тус тус хангах зорилгоор үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан гүйцэтгэлд хяналт тавин ажиллаж, улирал бүр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт тайлагнан ажиллаж байна.

1.1. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн “Журамд өөрчлөлт оруулах тухай” 491 дүгээр тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор 1 ажил төлөвлөсөн бөгөөд 100 хувийн биелэлттэйгээр хэрэгжиж байна. Төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг тухайн төрийн албан хаагчийн төрийн байгууллагад ажилласан хугацааг харгалзан түүний албан тушаалын сарын үндсэн цалингаас 1-25 хүртэлх хувиар байгууллагын нийт 18 албан хаагчдад олгож, тус тогтоолыг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн даган мөрдөж байна.

1.2. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 488 дугаар тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор 1 ажил төлөвлөсөн бөгөөд 100 хувийн биелэлттэйгээр хэрэгжиж байна. Тус тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбогдуулан шаардагдах хөрөнгийг батлагдсан төсөвтөө багтаан хэрэгжүүлж, 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөн ажиллаж байна.

1.3. Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн “2023-2024 оныг авлигатай тэмцэх жил болгон зарлах тухай” 49 дүгээр тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор 3 ажил төлөвлөсөн бөгөөд 100 хувийн биелэлттэйгээр хэрэгжиж байна.

- Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”, газрын даргын 2021 оны А/33 дугаар тушаалаар албан хаагчийн ёс зүйн дүрмийг шинэчлэн баталсан ба цахим хуудас болон мэдээллийн самбартаа тогтмол байршуулан ажиллагаандаа хэрэгжүүлэн, мөрдөж, зөрчил, дутагдалгүй ажиллаж байна.

- Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд иргэд олон нийтийг татан оролцуулах, ил тод, нээлттэй байдлыг хангах авлига, ашиг сонирхлын

“Улаанбаатар лифт” НӨҮГ-ын 2023 оны үйл ажиллагааны жилийн эцсийн тайлан

зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн байгууллагын төлөвлөгөөг 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр газрын даргаар батлуулан байгууллагын цахим хуудсанд байршуулсан. Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчилж, байгууллагын цахим хуудсанд 4 мэдээлэл, хэвлэмэл хуудсаар 3 мэдээллийг тус тус байршуулсан.

- Авлигатай тэмцэх газар болон Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлэг мэдүүлэх үүрэгтэй мэдүүлэг гаргагчдад зориулсан цахим сургалтад газрын дарга Д.Ган-Эрдэнэ, ахлах нягтлан бодогч З.Ариунтуяа нар 2023 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр хамрагдсан.

- Үйл ажиллагаандаа “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай”, “Авлигын эсрэг хуулийг тус тус мөрдөн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хуулиар хориглоогүй мэдээллийг иргэдэд нээлттэй, хүндрэл чирэгдэлгүй өгөх үүднээс Нийслэлийн эрх зүйн мэдээллийн санд 2017-2023 оны тушаалуудыг байршуулан авлигаас ангид ажиллаж байна.

1.4. Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” 301 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах үйл ажиллагаатай холбогдуулан 1 арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд 100 хувийн биелэлттэйгээр хэрэгжсэн байна. Үүнд:

“Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж, батлах ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ыг 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн даган мөрдөж байна.

1.5. Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 442 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах үйл ажиллагааны хүрээнд 1 арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд 100 хувийн биелэлттэйгээр хэрэгжсэн байна. Үүнд:

“Журам шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн 301 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ын өөрчлөгдсөн хэсэг, заалтыг 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрөөс эхлэн даган мөрдөж байна.

1.6. Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн “Шил ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” 01 дүгээр албан даалгаврыг хэрэгжүүлэх үйл ажиллагаатай холбогдуулан хэрэгжилтийг хангах зорилгоор 2 арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд 100 хувийн биелэлттэйгээр хэрэгжсэн байна.

- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар заалтад заасан Нээлттэй мэдээллүүдийг байгууллагын цахим хуудаст байршуулсан талаарх явцын мэдээллийг Нийслэлийн Засаг даргын тамгын газарт solongo.m@ulaanbaatar.mn цахим шуудангаар 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр хүргүүлсэн. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсээс 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр цахим сайтны нийтийн мэдээллийн ил тод байдлын үнэлгээг хийж, 100 хувийн биелэлттэй үнэлэгдсэн. Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт цахим хуудасны ил тод байдлыг 98 шалгуур үзүүлэлтээр үнэлж, 2023 оны 06 дугаар 16-ны өдөр хүргүүлэхээр ажиллаж байна.

- Үйл ажиллагаандаа “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай”, “Авлигын эсрэг хуулийг тус тус мөрдөн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хуулиар хориглоогүй мэдээллийг

“Улаанбаатар лифт” НӨҮГ-ын 2023 оны үйл ажиллагааны жилийн эцсийн тайлан

иргэдэд нээлттэй, хүндрэл чирэгдэлгүй өгөх үүднээс Нийслэлийн эрх зүйн мэдээллийн санд 2017-2023 оны тушаалуудыг байршуулан авлигаас ангид ажиллаж байна.

1.7. Засгийн газрын 23 дугаар хуралдаанаар “Шил ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” авч хэлэлцсэнтэй холбогдуулан гаргасан хуралдааны тэмдэглэлийн хэрэгжилтийг хангах зорилгоор хэрэгжилтийг 3 ажил төлөвлөсөн бөгөөд 100 хувийн биелэлттэйгээр хэрэгжсэн байна. Дараах чиг үүргийг хэрэгжүүлэн ажилласан. Үүнд:

- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу байгууллагын <http://ublift.ub.gov.mn/> цахим хуудсанд тогтмол баяжуулалтыг хийж, иргэд, олон нийтийн оролцоог ханган ажиллаж байна. 2023 оны жилийн эцсийн байдлаар нийт 81 мэдээ, мэдээллийг байршуулсан байна.

- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар заалтад заасан Нээлттэй мэдээллүүдийг байгууллагын цахим хуудаст байршуулсан талаарх явцын мэдээллийг Нийслэлийн Засаг даргын тамгын газарт solongo.m@ulaanbaatar.mn цахим шуудангаар 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр хүргүүлсэн. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсээс 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр цахим сайтны нийтийн мэдээллийн ил тод байдлын үнэлгээг хийж, 100 хувийн биелэлттэй үнэлэгдсэн. Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт цахим хуудасны ил тод байдлыг 98 шалгуур үзүүлэлтээр үнэлж, 2023 оны 06 дугаар 16-ны өдөр хүргүүлэхээр ажиллаж байна.

-Үйл ажиллагаандаа “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай”, “Авлигын эсрэг хуулийг тус тус мөрдөн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хуулиар хориглоогүй мэдээллийг иргэдэд нээлттэй, хүндрэл чирэгдэлгүй өгөх үүднээс Нийслэлийн эрх зүйн мэдээллийн санд 2017-2023 оны тушаалуудыг байршуулан авлигаас ангид ажиллаж байна.

1.8. Нийслэлийн Засаг даргын “Төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” 2023 оны А/32 дугаар захирамжийг хэрэгжүүлэх үйл ажиллагаатай холбогдуулан 1 арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд 90 хувийн биелэлттэйгээр хэрэгжсэн байна. Үүнд:

2022-2023 он дамжин хэрэгжсэн ажил:

Нийслэл, нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2022-2023 он дамжин хэрэгжиж буй нийтийн зориулалттай орон сууцны барилгын 20 цахилгаан шатны шинэчлэлтийн ажил 100 хувь бүрэн хэрэгжиж, улсын комисст хүлээлгэн өгч байнгын ашиглалтад оруулсан.

2023 онд хэрэгжсэн ажил:

- Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/105 дугаар захирамжийн хүрээнд нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинэчлэгдэх 4 цахилгаан шатны шинэчлэлийн ажлыг гүйцэтгэхээр “Оакс экспресс монголиа” ХХК шалгарч, 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдрөөс 2023 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн хооронд гүйцэтгэж, 2023 оны 09 дүгээр сарын 22-ны өдөр улсын комисст хүлээлгэн өгч байнгын ашиглалтад оруулсан.

- Нийслэлийн Засаг даргын А/966 дугаар захирамжийн хүрээнд нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжиж буй нийтийн зориулалттай орон сууцны 2 цахилгаан шат шинэчлэлийн ажлыг “Оакс экспресс монголиа” ХХК гүйцэтгэхээр шалгарч,

“Улаанбаатар лифт” НӨҮГ-ын 2023 оны үйл ажиллагааны жилийн эцсийн тайлан

2023 оны 11 дүгээр сарын 02-ны өдрөөс ажлаа эхэлж 2024 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн хооронд гүйцэтгэхээр гэрээ байгуулсан.

- Нийслэлийн Засаг даргын А/966 дугаар захирамжийн хүрээнд нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжиж буй нийтийн зориулалттай орон сууцны 2 цахилгаан шат шинэчлэлийн ажлыг “Фүшили элеватор” ХХК гүйцэтгэхээр шалгарч, 2023 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 2024 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн хооронд гүйцэтгэхээр гэрээ байгуулсан.

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Беларусь Улсын Засгийн газар хоорондын хөнгөлөлттэй зээлийн хүрээнд хэрэгжих “Улаанбаатар хотын нийтийн зориулалттай орон сууцны 130 цахилгаан шатыг шинэчлэх төсөл”-ийн зээлийн эргэн төлөлт нь тодорхойгүй, цаг үеийн нөхцөл байдал (Оросын Холбооны Улс болон Украин Улсын хооронд үүссэн нөхцөл байдал)-аас шалтгаалан хэрэгжих нь тодорхойгүй болоод байна.

1.9. Нийслэлийн Засаг даргын “Төсвийн хуваарь батлах тухай” 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн А/47 дугаар захирамжийг хэрэгжүүлэх зорилгоор 2 арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд 100 хувийн биелэлттэйгээр хэрэгжсэн байна.

- 2023 оны нийслэлийн төсвийн орлогын сар, улирлын хуваарийг батлагдсан, оны эхнээс төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг жигд ханган, орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд гэрээт ААНБ, СӨХ-дын тоог нэмэгдүүлж техник үйлчилгээнээс орох орлогыг өсгөх, техникийн ээлжит магадлалыг өнгөрсөн оныхоос нэмэгдүүлэх зорилт тавин ажиллаж байна.

- Тайлант хугацаанд “Дэнж 54” СӨХ-ны 1, “Монта виста 93” СӨХ-ны 1, “Оргил 58” СӨХ-ны 3, “Чандмана” СӨХ-ны 3, “Сансар өргөө” СӨХ-ны 1, “Бадрах” СӨХ-ны 2, “Шинэ хангай” СӨХ-ны 10, “Очир 72” СӨХ-ны 1, “Нарлаг 34” СӨХ-ны 2, “Нийслэлийн онцгой байдлын газар”-ын 4, “Нархан” СӨХ-ны 1, “Баян төгөл” СӨХ-ны 1, “Тэмүүлэл 10” СӨХ-ны 1, “Есөн-Эрдэнэ” СӨХ-ны 1, “Дэвшил 8” СӨХ-ны 1, “Их монгол” СӨХ-ны 2, “Улсын II төв эмнэлэг”-ийн 1 лифт, нийт 37 лифтэнд засвар, техник үйлчилгээ хийж гүйцэтгэх гэрээг шинээр байгуулж ажилласан.

Мөн олгогдсон тусгай зөвшөөрлийн хүрээнд 87 аж ахуйн нэгж байгууллагын хүсэлтийн дагуу гэрээт болон гэрээт бус 376 цахилгаан шатанд техникийн ээлжит магадлалын ажлыг хийж гүйцэтгэсэн.

Тайлант хугацаанд нийт 138,000,000 төгрөгийн орлогыг Нийслэлийн төсөвт төвлөрүүлэх байснаас, 183,127,345 төгрөгийн орлогыг төвлөрүүлэн ажилласан. Биелэлт 140 хувьтай байна.

1.10. Нийслэлийн Засаг даргын “Захиалагчийн хяналт тавих тухай” 2023 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн А/101 дүгээр захирамжийг хэрэгжүүлэх зорилгоор 1 арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд 100 хувийн биелэлттэйгээр хэрэгжсэн байна.

- “UB ENGINEERING” төслийн мэдээллийн сангийн дата бүрдүүлэх ажлын хүрээнд <https://test.ubengineering.gov.mn/> сайтад гэрээт 53 ААНБ, СӨХ-дын мэдээлэл, засвар үйлчилгээ хариуцаж байгаа ААНБ мэдээлэл, болон 150 цахилгаан шатны мэдээллийг оруулж, QR кодыг үүсгээд байна.

Мөн өөрийн байгууллагад байгаа бүртгэл, судалгаанд тулгуурлан гэрээгээр хариуцан ажилладаггүй 2000 лифтний мэдээллийг тус системд оруулж бүртгэлжүүлсэн.

1.11. Нийслэлийн Засаг даргын “Эрх шилжүүлэх тухай” 2023 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн А/200 дугаар захирамжийг хэрэгжүүлэх зорилгоор 1 арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд 100 хувийн биелэлттэйгээр хэрэгжсэн байна.

Нийслэлийн Засаг даргын 2023 оны “Эрх шилжүүлэх тухай” А/200 дугаар захирамжийн хүрээнд гүүрэн гарцуудын цахилгаан шатуудыг 2023 оны 04 дүгээр сарын 15-наас 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр хүртэл хэвийн найдвартай ажиллуулах бэлтгэл ажлыг ханган лиффтнүүдийн өдөр тутмын хэвийн ажиллагааг хариуцан ажиллаж байна. Явган хүний гүүрэн гарцын цахилгаан шатны арчлалт, засварын ажлыг гүйцэтгэх №23/03-20 тоот гэрээг Нийслэлийн Засаг даргын тамгын газартай байгуулж урсгал засварын ажлыг үе шаттайгаар хийж гүйцэтгэж байна.

Явган хүний гүүрэн гарцуудын 8 цахилгаан шатуудад гарсан томоохон эвдрэл гэмтэл байхгүй хэвийн ажиллаж байна.

1.12. Нийслэлийн Засаг даргын “Эрх шилжүүлэх тухай” 2023 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн А/242 дугаар захирамжийг хэрэгжүүлэх зорилгоор 1 арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд 100 хувийн биелэлттэйгээр хэрэгжсэн байна.

- Төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа цахилгаан шат шинэчлэлтийн ажилд холбогдох дүрэм, Барилга, замын ажил гүйцэтгэхэд иргэдийн аюулгүй байдлыг хангах ерөнхий шаардлага, Цахилгаан шат түүнд тавигдах ерөнхий шаардлага стандартыг мөрдүүлэн хяналт тавин ажиллаж байна. Мөн Захирамжаар батлагдсан төлөвлөгөөг хэрэгжүүлэхтэй холбогдуулан байгууллагын Дотоод хяналт шалгалтын төлөвлөгөөнд 2 ажлыг тусгаж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Цахилгаан шат түүнд тавигдах ерөнхий шаардлага стандартыг Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ээлжит бус Х хуралдаанаар баталсан. Тус стандартыг мөрдүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих, аж ахуйн нэгж байгууллагуудад сурталчлан таниулах ажлыг 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдөр Хотын стандарт, хяналтын газартай хамтарч Баянгол дүүргийн Сууц Өмчлөгчийн холбоодын удирдлагуудад танилцуулж ажилласан.

1.13. Нийслэлийн Засаг даргын "Стратегийн команд штабын сургууль зохион байгуулах тухай" 2023 оны А/194 дүгээр захирамжийг хэрэгжүүлэх зорилгоор 1 арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд 100 хувийн биелэлттэйгээр хэрэгжсэн байна. Үүнд:

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 339 дүгээр тогтоолоор батлагдсан “Гамшгийн аюулын зарлан мэдээллийн дохио дамжуулах журам”, 340 дүгээр тогтоолоор батлагдсан “Гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх журам”-ыг хэрэгжүүлэх хүрээнд орон даяар зарлан мэдээллийн дохиогоор ажиллах нэгдсэн дадлага, сургуулилтад 2023 оны 06 дугаар сарны 08-ны өдрийн байгууллага хамт олноороо идэвхтэй оролцлоо.

Байгууллагын албан хаагчид газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх, мэдлэг чадварт суралцах дадлага хийсэн. Үүнд:

- Аюулгүй орон зайг тодорхойлох;
- Гал гарч болох эх үүсвэрүүдийн салгах;
- Бат бөх ширээн доогуур орох;
- Даацын хана налж суух;
- Сандралгүй тайван байж, шууд гарч гүйлгүй, чичирхийллийг намдах хүртэл хүлээх зэрэг болно.

Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор 16:00 цагт албан хаагчид өөрсдийн толгойг хамгаалж, аюулгүй талбайд гарч зогсож, болзошгүй эрсдэлээс өөрсдийгөө хамгаалсан.

1.14. Нийслэлийн Засаг даргын 2023 оны “Журам батлах тухай” А/1133 дугаар захирамжийн хүрээнд 1 арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд 100 хувийн биелэлттэйгээр хэрэгжсэн байна. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан мэдээллийг ulaanbaatar.mn цахим хуудсанд байршуулах, түгээх, ашиглах, цахим хуудасны хэвийн үйл ажиллагаа болон байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг ханган ажиллаж байна.

1.15. Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 06 дугаар хуралдаанаар иргэдээс нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн 2023 оны 1 дүгээр улирлын тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан хэрэгжилтийг хангах зорилгоор 4 арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд 100 хувийн биелэлттэйгээр хэрэгжсэн байна. Үүнд:

- 2023 оны жилийн эцсийн байдлаар иргэдээс манай байгууллага, албан тушаалтанд гаргасан 13 өргөдөл, гомдол, санал хүсэлтийг бүх талаас нь нягтлан судалж, хууль зүйн үндэслэлтэй нэг мөр эцэслэн шийдвэрлэж, хуулийн хугацаанд иргэнд хариу өгч ажилласан.

- Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд хийх дүн шинжилгээг сайжруулан, өргөдөл, гомдлын шалтгаан нөхцлийг байгууллагын үйл ажиллагааны чиглэл, бүтцийн нэгж, албан хаагч гэсэн байдлаар нарийвчлан судалж, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хугацаа, зөрчлийн үзүүлэлтийг бууруулах шийдвэрлэлтийг сайжруулах чиглэлээр тусгай төлөвлөгөө боловсруулан, биелэлтийг улирал тутам нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвд тайлагнан, мөн иргэдээс гаргасан саналыг байгууллагын үйл ажиллагаанд тусган хэрэгжүүлсэн байдлыг тайлан, мэдээнд тусгайлан оруулж, байгууллагын цахим хуудаст ил тод, нээлттэй байршуулж хэвшүүлсэн.

- Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын ERP системд ажиллах байгууллагын нийт албан хаагчдын чадавхийг дээшлүүлэн, системд албан хаагчдыг бүртгэх, мэдээллийг шинэчлэх, засварлах арга хэмжээг тухай бүр шуурхай гүйцэтгэж, албан хаагчдад заавар, зөвлөгөөг тогтмол өгч ажиллаж байна.

- Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд нь шийдвэрлээгүй, тайлан мэдээг дээд шатны байгууллагад тайлагнаж ажиллаагүй албан тушаалтанд хариуцлага тооцож, өргөдөл, гомдлын тайлан мэдээнд тусгах, бүх шатны байгууллага, албан тушаалтныг мэдээллээр хангах ажлыг тогтмол зохион байгуулж ажиллахыг холбогдох ажилчдад үүрэг болгосон. 2023 оны жилийн эцсийн байдлаар хуулийн хугацаанд нь шийдвэрлээгүй өргөдөл, гомдол байхгүй байна.

2.16. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2023 оны жилийн эцсийн хэрэгжилтийн дүн

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2023 оны жилийн эцсийн хэрэгжилтийн дүнг Хүснэгт 1-т үзүүлэв.

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН
2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ДҮН

		Нийт	Монгол Улсын хууль	УИХ-ын тогтоол, УИХ-ын байнгын хорооны тогтоол	Ерөнхийлөгчийн зарлиг	Улсын онцгой комиссын хурлын тэмдэглэл	Засгийн газрын тогтоол	Ерөнхий сайдын захирамж	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	Засгийн газрын албан даалгавар	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол	Нийслэлийн Засаг даргын захирамж	Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хурлын тэмдэглэл	Нийслэлийн онцгой комиссын хурлын тэмдэглэл
Хяналтад авсан нийт шийдвэрийн тоо		15	-	-	-	-	5	1	1	-	-	7	1	-
Хяналтад авсан нийт зүйл заалтын тоо		26	-	-	-	-	6	1	3	-	-	11	5	-
Бүрэн хэрэгжсэн	100%	14	-	-	-	-	5	1	1	-	-	6	1	-
Хэрэгжих шатанд	70%	1	-	-	-	-	-	-	-	-	-	1	-	-
Хэрэгжилт хангалтгүй	30%	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Хэрэгжээгүй	0%	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй /Үнэлэх боломжгүй/		-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Биелэлтийн дундаж		99 %	-	-	-	100%	100 %	-	-	-	-	97%	100%	100%

ГУРАВДУГААР БҮЛЭГ. “БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН”

3.1. Байгууллагын дүрмээр хүлээсэн үндсэн үүргийн хэрэгжилт

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2012 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 06 дугаар тогтоолоор “Улаанбаатар лифт” Нийслэлийн Өмчит Үйлдвэрийн Газар байгуулагдаж, Нийслэлийн Засаг Даргын 2012 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн А/184 дугаар захирамжаар тус газрын дүрмийг баталсан.

Дүрмээр хүлээсэн үндсэн үүрэгт:

3.1.1. Лифтний ашиглалт засвар үйлчилгээний чанарыг дээшлүүлэх, шинэ техник технологи нэвтрүүлэх, бодлого боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх зөвлөмж, аргачлал, удирдамж боловсруулна;

3.1.2. Олгогдсон тусгай зөвшөөрлийн хүрээнд аж ахуйн гэрээний үндсэн дээр лифтний магадлал туршилтын ажлыг Улаанбаатар хотын нийт лифтэнд хэрэгжүүлнэ;



3.1.3. Улс орон нутгийн төсвөөр шинэчлэгдэж буй лифтний зураг төсөв боловсруулах, захиалагчийн хяналт хийнэ;

3.1.4. Лифтний ашиглалт үйлчилгээний салбарыг мэргэжилтэй боловсон хүчнээр бэхжүүлэх, тэдний мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх, гадаад дотоодын сургалтад хамруулах, ажилтнуудыг байнгын курсээр бэлтгэх, давтан сургах гэж заасан ба дүрмээр хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх зорилгоор 4 зорилтын 18 арга хэмжээг авч хэрэгжүүлэн, хэрэгжилтийг ханган ажилласан.

3.1.1. Лифтний ашиглалт засвар үйлчилгээний чанарыг дээшлүүлэх, шинэ техник технологи нэвтрүүлэх, бодлого боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх зөвлөмж, аргачлал, удирдамж боловсруулна” гэсэн зорилтын хүрээнд:

3.1.1.1. Лифтний ашиглалт, засвар үйлчилгээг гэрээгээр хариуцдаг ААН байгууллага, СӨХ, иргэдийн цахилгаан шатны засвар үйлчилгээг технологийн дагуу чанартай гүйцэтгэх ашиглалтын найдвартай ажиллагаа болон аюулгүй байдлыг ханган ажиллах.



Гэрээгээр хамтран ажилладаг аж ахуй нэгж байгууллага, сууц өмчлөгчдийн холбоодын цахилгаан шатанд засвар, үйлчилгээ хийх хуваарийг сар бүр гарган, ерөнхий инженер танилцуулан батлуулж, хуваарийн дагуу тогтсон хугацаанд техник үйлчилгээг сар бүр хийж гүйцэтгэж байна. Жилийн байдлаар гэрээгээр хамтран ажилладаг 87 аж ахуй нэгж байгууллага, сууц өмчлөгчдийн холбоодын 376 лифтэнд засвар, техник үйлчилгээ хийж гүйцэтгэсэн бөгөөд давхардсан тоогоор нийт 1959 лифтэнд техник үйлчилгээ хийж, лифтний аюулгүй найдвартай ажиллагааг ханган, иргэд оршин суугчдын лифтээр аюулгүй зорчих нөхцөлөөр хангаж ажилласан. Тус хугацаанд техник үйлчилгээний орлого болох 125,787,900-н төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.



Гэрээгээр хамтран ажилладаг 60 аж ахуй нэгж байгууллага, сууц өмчлөгчдийн холбоодын 181 лифтний засвар, техник үйлчилгээг хариуцан ажиллаж байна.



Нийслэлийн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн А/200 дугаар эрх шилжүүлэх тухай захирамжийн хүрээнд гүүрэн гарцуудын цахилгаан шатуудыг 2023 оны 04 дүгээр сарын 15-наас 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр хүртэл хэвийн найдвартай ажиллуулах бэлтгэл ажлыг ханган лифтынүүдийн өдөр тутмын хэвийн ажиллагааг хариуцан ажиллаж байна. Явган хүний гүүрэн гарцын цахилгаан шатны арчлалт, засварын ажлыг гүйцэтгэх №23/03-20 дугаар гэрээг Нийслэлийн Засаг даргын тамгын газартай байгуулж урсгал засварын ажлыг үе шаттайгаар хийж гүйцэтгэж байна. Явган хүний гүүрэн гарцуудын 8 цахилгаан шатуудад гарсан томоохон эвдрэл гэмтэл байхгүй хэвийн ажиллаж байна.



3.1.1.2. "UB ENGINEERING" төслийн мэдээллийн сангийн дата бүрдүүлэх, мэдээллийн сан байгуулна.

Тус "UB ENGINEERING" төслийн мэдээллийн сангийн дата бүрдүүлэх, мэдээллийн сан бүрдүүлэх ажлын хүрээнд <https://test.ub-engineering.gov.mn> системд гэрээгээр хариуцан ажилладаг 53 аж ахуй нэгж байгууллага, сууц өмчлөгчдийн холбоодын 150 цахилгаан шатны мэдээллийг оруулж, лифт тус бүрд QR кодыг байршуулсан. Мөн өөрийн байгууллагад байгаа бүртгэл, судалгаанд тулгуурлан гэрээгээр хариуцан ажилладаггүй 2000 лифтын мэдээллийг тус системд оруулж бүртгэлийг үүсгээд байна.

3.1.1.3. Цахилгаан шат түүнд тавигдах ерөнхий шаардлагыг мөрдүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих, аж ахуйн нэгж байгууллагуудад сурталчлан таниулах ажлыг зохион байгуулна.

“Улаанбаатар лифт” НӨҮГ-ын 2023 оны үйл ажиллагааны жилийн эцсийн тайлан

- Цахилгаан шат түүнд тавигдах ерөнхий шаардлага стандартыг Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ээлжит бус X хуралдаанаар баталсан. Тус стандартыг мөрдүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих, аж ахуйн нэгж байгууллагуудад сурталчлан таниулах ажлыг 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдөр Хотын стандарт, хяналтын газартай хамтарч Баянгол дүүргийн сууц өмчлөгчдийн холбоодын удирдлагуудад танилцуулж ажилласан.

- Мөн 2023 оны 10 дугаар сарын 18-ны өдөр Монголын сууц өмчлөгчдийн холбоодын дээд зөвлөлөөс зохион байгуулсан “Танд тусалъя” Нийтийн аж ахуйн салбарын нээлттэй хаалганы өдөрлөгт БЗД-ийн салбар зөвлөлтэй хамтарч “Цахилгаан шат түүнд тавигдах ерөнхий шаардлага” хотын стандартын тараах материалыг СӨХ-дод тарааж, стандартыг танилцуулсан.



3.1.1.4. Гэрээт лифтний тоог нэмэгдүүлнэ.

Тайлант хугацаанд “Дэнж 54” СӨХ-ны 1, “Монта виста 93” СӨХ-ны 1, “Оргил 58” СӨХ-ны 3, “Чандмана” СӨХ-ны 3, “Сансар өргөө” СӨХ-ны 1, “Бадрах” СӨХ-ны 2, “Шинэ хангай” СӨХ-ны 10, “Очир 72” СӨХ-ны 1, “Нарлаг 34” СӨХ-ны 2, “Нийслэлийн онцгой байдлын газар”-ын 4, “Нархан” СӨХ-ны 1, “Баян төгөл” СӨХ-ны 1, “Тэмүүлэл 10” СӨХ-ны 1, “Есөн–Эрдэнэ” СӨХ-ны 1, “Дэвшил 8” СӨХ-ны 1, “Их монгол” СӨХ-ны 2, “Улсын II төв эмнэлэг”-ийн 1 лифт, нийт 37 лифтэнд засвар, техник үйлчилгээ хийж гүйцэтгэх гэрээг шинээр байгуулж ажилласан.

3.1.1.5. Лифт эзэмшигч, ашиглагч байгууллагуудын удирдлагуудад мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгч, шаардлагатай мэдээ, мэдээллээр хангаж ажиллана.

Баянгол дүүргийн лифт эзэмшигч, ашиглагч байгууллагуудын удирдлагуудад 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдөр Хотын стандарт, хяналтын газартай хамтарч Цахилгаан шат түүнд тавигдах ерөнхий шаардлага стандартыг танилцуулж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Мөн "UB ENGINEERING" төслийн мэдээллийн сангийн дата бүрдүүлэх ажлын хүрээнд Монголын сууц өмчлөгчдийн холбоодын дээд зөвлөлийн холбоотой хамтарч харьяа сууц өмчлөгчдийн холбоодод мэргэжил арга зүй зөвлөгөө өгч ажилласан.

3.1.1.6. Газрын хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны журмын хэрэгжилтэд хяналт тавих, нийт ажилчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт жилд 1 удаа хамруулах ажлыг зохион байгуулна.

Газрын хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны журмын хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. 2023 оны 3 дугаар улиралд нийт 17 ажилчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан.

Лифтний механикуудад өдөр тутмын ажлын байран дахь аюулгүй ажиллагааны зааварчилгааг тогтмол, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны давтан зааварчилгааг

улиралд 1 удаа өгч, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн журмыг мөрдүүлэн ажиллаж байна.


Тайлант хугацаанд инженер техникийн хэсгийн албан хаагчдыг зуны ажлын хувцас, ажлын бээлий зэрэг шаардлагатай хөдөлмөр хамгааллын хэрэгслээр бүрэн хангаж ажиллалаа. Мөн Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн нөхцөлийг хангахад шаардлагатай нэг удаагийн маск болон анхан шатны тусламжийн хэрэгсэл, өдөр тутмын ажилд шаардлагатай багаж хэрэгслээр хангаж, хөдөлмөрийн аюулгүй байдлын нөхцөлийг хангаж ажилласан.

Инженер техникийн хэсгийн албан хаагчдад “Аюулгүй ажиллагааны 10 дүрэм”, “Оффисын аюулгүй байдал”, Хувийн хамгаалах хэрэгсэл”, “Хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах иргэн, ажилтны эрх үүрэг” зэрэг сэдвээр танилцуулах материал бэлтгэж албан хаагчдад танилцуулж ажилласан.

3.1.2. “Олгогдсон тусгай зөвшөөрлийн хүрээнд аж ахуйн гэрээний үндсэн дээр лифтний магадлал туршилтын ажлыг Улаанбаатар хотын нийт лифтэнд хэрэгжүүлнэ” гэсэн зорилтын хүрээнд:

3.1.2.1. Гэрээт ААНБ, СӨХ-ны хүсэлтийн дагуу лифтний техникийн ээлжит магадлалыг хийж, лифтний аюулгүй ажиллагааг хангуулж ажиллана.

Жилийн эцсийн байдлаар 87 аж ахуй нэгж байгууллага, сууц өмчлөгчдийн холбоодын нийт 376 лифтэнд техникийн ээлжит магадлалыг хийж гүйцэтгэсэн бөгөөд магадлалаар илэрсэн зөрчлийг лифт ашиглагч байгууллага болон засвар, техник үйлчилгээ гүйцэтгэгч мэргэжлийн байгууллагад мэдэгдэж, заавар зөвлөгөөг өгч лифтний хэвийн ажиллагааг хангуулан ажилласан. Техникийн ээлжит магадлалын актын ЛТААД-д заасан хугацаанд үйлдэж хувийг лифт ашиглагч байгууллагад өгсөн. Тус хугацаанд техник ээлжит магадлалын орлого болох 27,011,200-н төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна. Мөн 12 ААНБ, СӨХ-дын хүсэлтийн дагуу 15 цахилгаан шатны гэмтлийг тогтоож, гэмтлийн актыг холбогдох газарт хүргүүлсэн.



3.1.3. “Улс орон нутгийн төсвөөр шинэчлэгдэж буй лифтний зураг төсөв боловсруулах, захиалагчийн хяналт хийнэ” гэсэн зорилтын хүрээнд:

- Нийслэлийн төсөв, нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2022-2023 он дамжин хэрэгжсэн нийтийн зориулалттай орон сууцны барилгын 20 цахилгаан шат шинэчлэлийн ажил 100 хувь бүрэн хэрэгжиж улсын комисст хүлээлгэн өгсөн.

- Нийслэлийн төсөв, нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2023 онд хэрэгжиж буй нийтийн зориулалттай орон сууцны барилгын 8 цахилгаан шат шинэчлэлийн ажил:

“Улаанбаатар лифт” НӨҮГ-ын 2023 оны үйл ажиллагааны жилийн эцсийн тайлан

Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/105 захирамжийн хүрээнд нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинэчлэгдэх 4 цахилгаан шатны шинэчлэлийн ажлыг гүйцэтгэхээр “Оакс экспресс Монголиа” ХХК шалгарч, гэрээний дагуу цахилгаан шатны угсралтын ажил 100 хувь хийгдэж 2023 оны 09 дүгээр сарын 22-ны өдөр улсын комисст хүлээлгэж өгсөн.

Нийслэлийн Засаг даргын А/966 дугаар захирамжийн хүрээнд хэрэгжиж буй Нийтийн зориулалттай орон сууцны 2 цахилгаан шатны шинэчлэлтийн ажлыг “Оакс экспресс Монголиа” ХХК нь 2023 оны 11 дүгээр сарын 02-ны өдрөөс 2024 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэлх хугацаанд гүйцэтгэх гэрээ байгуулж, цахилгаан шатыг захиалсан байна.

Нийслэлийн Засаг даргын А/966 дугаар захирамжийн хүрээнд хэрэгжиж буй Нийтийн зориулалттай орон сууцны 2 цахилгаан шатны шинэчлэлтийн ажлыг “Фүшили элеватор” ХХК нь 2023 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 2024 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийг хүртэлх хугацаанд гүйцэтгэх гэрээ байгуулж, цахилгаан шатыг захиалсан байна.



3.1.4. “Лифтний ашиглалт үйлчилгээний салбарыг мэргэжилтэй боловсон хүчнээр бэхжүүлэх, тэдний мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх, гадаад дотоодын сургалтад хамруулах, ажилтнуудыг байнгын курсээр бэлтгэх, давтан сургах зэрэг боловсон хүчний нэгдсэн бодлого явуулах” гэсэн зорилтын хүрээнд:

3.1.4.1 Хамтран ажиллах гэрээний дагуу шинээр лифтчин бэлтгэх сургалтад иргэдийг бүртгэж, сургалтыг зохион байгуулна.

- “Голден рич одц” ХХК-тай хамтран ажиллах гэрээний хүрээнд 2023 оны 03 дугаар сарын 24-27-ны өдрүүдэд лифтчин бэлтгэх сургалтыг зохион байгуулж, шинээр 7 лифтчин, 2023 оны 11 дүгээр сарын 25-28-ны өдрүүдэд 5 лифтчинг тус тус бэлтгэж мэргэжлийн үнэмлэх олгосон.

- 2023 оны 11 дүгээр сарын 28, 12 дугаар сарын 04-ны өдрүүдэд лифтчингийн үнэмлэхийн хугацаа сунгах давтан сургалтыг зохион байгуулж 12 лифтчингийн үнэмлэхийн хугацааг сунгасан.

3.1.5. “Санхүүгийн удирдлагыг оновчтой хэрэгжүүлэх, өмч хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, Нийслэлийн өмч хөрөнгийг хууль тогтоомжид заасан эрх хэмжээний дотор үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн эзэмшиж ашиглах” гэсэн зорилтын хүрээнд:

3.1.5.1. Санхүүгийн удирдлагыг оновчтой хэрэгжүүлэх, өмч хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, Нийслэлийн өмч хөрөнгийг хууль тогтоомжид заасан эрх хэмжээний дотор үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн эзэмшиж, ашиглах:

- 2022 оны санхүүгийн 04 дүгээр улирлын тайланг хугацаанд нь гарган холбогдох байгууллагад хүргүүлсэн. 2023 оны 1, 2, 3 дугаар улирлын санхүүгийн тайланг 4 дүгээр сарын 18, 7 дугаар сарын 20, 10 дугаар сарын 20-ны өдөр тус тус Нийслэлийн Санхүү, төрийн санд хүргүүлсэн.

- 2023 оны 1-11 дүгээр саруудын Нийгмийн даатгалын тайланг хуулийн хугацаанд нь Баянзүрх дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэст тушаасан. Тайланг <http://app.ndaatgal.mn/> сайтад шивж баталгаажуулсан.

- 2022 оны 04 дүгээр улирлын Татварын тайланг, Нийслэлийн Татварын газарт 2023 оны 02 дугаар сарын 10-нд, 2023 оны 1, 2, 3 дугаар улирлын тайланг 2023 оны 4 дүгээр сарын 10, 7 дугаар сарын 10, 10 дугаар сарын 20-ны өдөр тус тус хуулийн хугацаанд нь тайлагнасан.

- Татварын 04 дүгээр улирлын тайланг <https://www.etax.mta.mn/> сайтад 2023 оны 02 дугаар сарын 10-нд шивж оруулсан.

- 2023 оны 1-11 дүгээр саруудын үйл ажиллагаа болон нэмэлт санхүүжилт, дансны сарын мэдээг гаргаж сар бүрийн 01-нд Нийслэлийн Санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлсэн.

Төсвийн хөрөнгийн зарцуулалтын дүн мэдээг сар бүрийн 08-ны өдрийн дотор шилэн дансны <http://www.shilendans.ub.gov.mn/home> цахим хуудсанд бүртгэж үйл ажиллагаандаа шилэн дансны тухай хуулийг мөрдөн хэрэгжүүлж ажиллалаа.

- Нийслэл дэх Төрийн аудитын газрын хуваарийн дагуу “Эс Жи Эм Ди” ХХК-аар 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайланд аудит хийлгэж, 2023 оны 03 дугаар сарын 15-ны өдөр зөрчилгүй дүгнэлт гаргуулсан. Зөвлөмжийн хэрэгжилтийг 2023 оны 05 дугаар сарын 24, 09 дүгээр сарын 21-ний өдрүүдэд тус тус Нийслэл дэх төрийн Аудитын газарт хүргүүлсэн.

- Өмч хамгаалах байнгын зөвлөл нь байгууллагын эд хөрөнгийн гэнэтийн болон ээлжит тооллогыг зохион байгуулан эд хөрөнгийн бүртгэлийг нягтлан сайжруулж, эвдэрсэн эд хөрөнгийг холбогдох эздээр төлүүлж өмч хөрөнгийн бүрэн бүтэн байдал, хадгалалт хамгаалалтад хяналт тавин ажиллаж байна.

- Өмч хамгаалах байнгын зөвлөл нь байгууллагын эд хөрөнгийн гэнэтийн болон ээлжит тооллогыг зохион байгуулан эд хөрөнгийн бүртгэлийг нягтлан сайжруулж, эвдэрсэн эд хөрөнгийг Газрын даргын 2023 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн А/11 дугаар тушаалаар Бараа материал дансанд бүртгэлтэй 3,811,725 төгрөгийн үнэ бүхий ашиглалтын шаардлага хангахгүй материалыг акталж данс бүртгэлээс хасаж өмч хөрөнгийн бүрэн бүтэн байдал, хадгалалт хамгаалалтад хяналт тавин зөрчил гаргалгүй ажиллаж байна.

- Байгууллагын өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, хөрөнгийн данс бүртгэлд тусгасан байдалд хяналт тавих үүднээс эд хөрөнгийн тооллогын ажлыг эхний хагас жилийн байдлаар 2023 оны 06 дугаар сарын 12-15-ны өдрүүдэд зохион байгуулсан.

- Үндсэн хөрөнгийн тооллогыг төлөвлөгөөт хуваарийн дагуу хийж Нийслэлийн өмчийн харилцааны газрын даргын 2023 оны 06-р сарын 02-ны өдрийн А/139 дүгээр тушаал, байгууллагын даргын 2023 оны 06-р сарын 28-ны өдрийн А/10 дугаар тушаалын дагуу Эргэлтийн бус хөрөнгөд бүртгэлтэй Тавилга эд хогшил данснаас 517,524 төгрөг, Тоног төхөөрөмж данснаас 3,497,806 төгрөг, нийт 4,015,330 төгрөгийн хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хассан.

- Нийслэлийн Өмчийн харилцааны газраас өмч эзэмшүүлэх гэрээг 2023 оны 06 дугаар сарын 07-ны өдөр дүгнэсэн бөгөөд зөвлөмжийн дагуу мод бут, гадна хашааг бүртгэлжүүлэх ажлыг зохион байгуулсан. Үндсэн хөрөнгийн бүртгэлд байгаа бараа

материалын шинж чанартай хөрөнгийг бараа материалын дансанд шилжүүлэн бүртгэж байна.

- 2023 оны 02 дугаар сарын 25-нд Нийслэлийн Өмчийн харилцааны газрын Өмчийн нэгдсэн бүртгэлийн санд хөрөнгийн өөрчлөлт болон 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа шивж илгээсэн.

- Төлөвлөгөөт зардлын хэтрэлт, хэмнэлт төлөвлөгөөт орлого бүрдүүлэлтийг даргын зөвлөлийн хурал, ажилчдын шуурхай зөвлөгөөн (сар тутамд)-д тухай бүр танилцуулан, шаардлагатай арга хэмжээг авч ажиллаж байна.

Тайлант хугацаанд нийт 138,000,000 төгрөгийн орлогыг Нийслэлийн төсөвт төвлөрүүлэх байснаас, 207,757,294 төгрөгийн орлогыг төвлөрүүлэн ажилласан. Биелэлт 170 хувьтай байна. Үүнд:

Захиалагчийн хяналтаас 54,838,194 төгрөг, техник үйлчилгээнээс 125,787,900 төгрөг, магадлалаас 27,011,200 төгрөг, лифтчингийн сургалтаас 120,000 төгрөгийн орлогыг тус тус бүрдүүлсэн байна.

3.2. Байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн дотоод ажил үйлчилгээний хэрэгжилт

3.2.1. Архив, албан хэрэг хөтлөлт, хариутай албан бичгийн шийдвэрлэлтийн байдал болон бусад арга хэмжээ:

3.2.1.1. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн www.erp.ulaanbaatar.mn системийн edoc программд байгууллагад ирсэн албан бичгийг хүлээн авч байгууллагын “Албан хэрэг хөтлөлтийн журам”-ын дагуу ангилан бүртгэж, холбогдох ажилтанд шилжүүлэн ажиллаж байна. 2023 оны жилийн эцсийн байдлаар нийт 375 албан бичиг бүртгэгдсэнээс 66 хариутай албан бичиг хүлээн авсан ба тухай бүр хугацаанд нь хариу өгч шийдвэрлэж ажилласан.

Нийт явуулсан албан бичиг 237 байна.

Албан бичгийн шийдвэрлэлтийн байдал болон хариутай албан бичгийг хугацаанд нь шийдвэрлэж байгаа эсэхэд тогтмол хяналт тавин зөрчил гаргалгүй ажилласан.

3.2.1.2. 2023 оны Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг байгууллагын нийт албан хаагчдаас санал авч байгууллагын дэргэдэх БНШК-ын 2022 оны 03-р сарын 31-ний өдрийн 01 дүгээр хурлаар хэлэлцэж нийт 74 хадгаламжийн нэгж баталсан.

- 2023 оны 02 дугаар сарын 15, 16-ны өдрүүдэд ажилтнуудаас баримт бичиг хүлээн авах графикийн дагуу байгууллагын 2022 оны үйл ажиллагааны явцад үүсч хөтлөгдсөн баримт бичгүүдээр ХХНЖ-ын дагуу хэрэг бүрдүүлэх ажлыг зохион байгуулсан. Нийт 107 хадгаламжийн нэгж үүссэнээс 70 жил хадгалах-5, түр хадгалах-52, байнга хадгалах-50 баримтыг тус тус ангилан төрөлжүүлж хэрэг бүрдүүлсэн.

- Архивын баримтын хадгалалтын тохиромжтой нөхцөлийг бүрдүүлж, баримтын бүрэн бүтэн байдлыг ханган, хавтас, наалт нь нугарсан болон салсан баримтуудыг шинэчлэн засварлалаа.

- Нийслэлийн архивын газрын Archive Edoc программд 2022 онд үүсч хөтлөгдсөн Захирамжлалын 45 баримт бичгийг агуулга тодорхойлон шивж бүртгэлд оруулан ажилласан. Захирамжлалын нийт 45 баримтыг <http://erp.ulaanbaatar.mn> нэгдсэн сайтын ArchiveEdoc системд агуулга тодорхойлон Үндсэн үйл ажиллагааны асуудлаар гаргасан даргын А

тушаал 32, Хүний нөөцийн асуудлаар гаргасан даргын Б тушаал 13 ширхэгийг шивж оруулсан байна.

3.2.1.3. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журмын 1 дүгээр хавсралтад заасны дагуу байгууллагын хагас, бүтэн жилийн тайланг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн.

3.2.1.4. Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн, мөрдөж, зөрчил, дутагдалгүй ажиллаж байна.

3.2.1.5. Үйл ажиллагаандаа “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай”, “Авлигын эсрэг” хуулийг тус тус мөрдөн авлигаас ангид ажиллаж байна.

3.3. Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилт

Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар байгууллагын Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг хангах зорилгоор 7 арга хэмжээг авч хэрэгжүүлэн, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

3.3.1. Мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх зорилгоор зохион байгуулагдсан сургалтад холбогдох ажилчид хамрагдаж, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлсэн.

- Хотын стандарт, хяналтын газраас зохион байгуулсан “Хотын стандарт хэлэлцүүлэг”-т Хяналтын инженер Ц.Уранбилэг, Б.Байгаль нар 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр хамрагдсан.

- Нийслэлийн Архивын газраас зохион байгуулсан шинэчлэн батлагдсан Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль тогтоомж, Архив албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журмын талаар мэдлэг олгох сургалтад 2023 оны 02 дугаар сарын 15-ны өдөр Архив, бичиг хэрэг, дотоод асуудал хариуцсан мэргэжилтэн Н.Нарангуа сургалтад хамрагдлаа.

- Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газраас зохион байгуулсан “Засгийн газрын худалдан авах ажиллагааны үндэс” сэдэвт сургалтад Хяналтын инженер Ц.Уранбилэг 2023 оны 02 дугаар сарын 02-ны өдөр хамрагдсан.

- Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас 2023 оны 03 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулагдсан төлбөр тооцооны цахим системийг нэвтрүүлэхтэй холбогдуулан “Төсвийн гүйлгээг цахим системээр хяналт тавих” сэдэвт сургалтад газрын дарга Д.Ган-Эрдэнэ, ахлах нягтлан бодогч З.Ариунтуяа нар хамрагдсан.

- Архивын Ерөнхий газраас зохион байгуулсан Албан хэрэг хөтлөлт, архивын ажилтны мэргэжлийн сургалтад 2023 оны 03 дугаар сарын 01-31-ний өдрүүдэд Архив, бичиг хэрэг, дотоод асуудал хариуцсан мэргэжилтэн Н.Нарангуа сургалтад хамрагдаж мэргэжлийн үнэмлэх авсан.

- Нийслэлийн Хүний нөөцийн хөгжлийн төвөөс зохион байгуулсан “Бизнесийн процессын дахин загварчлал” сургалтад 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр Архив, бичиг хэрэг, дотоод асуудал хариуцсан мэргэжилтэн Н.Нарангуа хамрагдсан.

- Монголын барилгачдын нэгдсэн холбооноос зохион байгуулсан Өргөх, тээвэрлэх машин, тоног төхөөрөмжийн ашиглалтын мэргэших инженерийн багц сургалтад 2023 оны 05

“Улаанбаатар лифт” НӨҮГ-ын 2023 оны үйл ажиллагааны жилийн эцсийн тайлан

дугаар сарын 15-26-ны өдрүүдэд Хяналтын инженер Б.Байгаль хамрагдаж, мэргэшсэн инженерийн зэрэгтэй болсон.

- Нийслэлийн Хүний нөөцийн хөгжлийн төвөөс зохион байгуулсан "Бусдад харилцаагаар нөлөөлөх нь" сургалтад 2023 оны 06 дугаар сарын 05-ны өдөр Хүний нөөцийн мэргэжилтэн Ц.Өсөхжаргал хамрагдаж мэргэжлийн ур чадварыг дээшлүүлсэн.

- Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан "Хөгжлийн бодлогын баримт бичгийн төлөвлөлт, тайлагналт, хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй" сургалтад 2023 оны 06 дугаар сарын 06-ны өдөр Хүний нөөцийн мэргэжилтэн Ц.Өсөхжаргал хамрагдаж мэргэжлийн ур чадварыг дээшлүүлсэн.

- Нийслэлийн Хүний нөөцийн хөгжлийн төвөөс зохион байгуулсан "Хууль эрх зүй" сургалтад Ахлах нягтлан бодогч Д.Санжням 2023 оны 09 дүгээр сарын 08-ны өдөр хамрагдсан.

- Нийслэлийн Хүний нөөцийн хөгжлийн төвөөс зохион байгуулсан "Цахим орчны боломж ашиглан ажлын бүтээмжээ нэмэгдүүлэх нь" сургалтад 2023 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр Ерөнхий инженер М.Энхбат, Ахлах нягтлан бодогч Д.Санжням, Хүний нөөцийн мэргэжилтэн Ц.Өсөхжаргал, Хяналтын инженер Б.Батзориг, Б.Байгаль, Архив, бичиг хэрэг, дотоод асуудал хариуцсан мэргэжилтэн Н.Нарангуа нар хамрагдсан.

- Нийслэлийн Хүний нөөцийн хөгжлийн төвөөс зохион байгуулсан "Төрийн албан хаагчийн гадаад дүр төрх, ёс зүй"-н сургалтад 2023 оны 09 дүгээр сарын 14-ний өдөр хяналтын инженер Б.Батзориг, жолооч Г.Бадамрагчаа нар хамрагдсан.

- Нийслэлийн Хүний нөөцийн хөгжлийн төвөөс зохион байгуулсан "Судалгааны арга зүй" сургалтад Архив, бичиг хэрэг, дотоод асуудал хариуцсан мэргэжилтэн Н.Нарангуа 2023 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр хамрагдаж, мэдлэг чадвараа дээшлүүллээ.

- Нийслэлийн Хүний нөөцийн хөгжлийн төвөөс нутгийн захиргааны байгууллагуудын хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдийн мэдлэг ур чадварыг тасралтгүй хөгжүүлэх, сайн туршлагаас харилцан суралцах, шилдэг туршлагыг түгээх замаар албан хаагчдын хөгжлийг дэмжих зорилгоор зохион байгуулсан "Харилцан суралцах арга зүй" сургалтад 2023 оны 10 дугаар сарын 04-ний өдөр Хүний нөөцийн мэргэжилтэн Ц.Өсөхжаргал хамрагдлаа.

- Төрийн албаны зөвлөлийн 7:4:10 сургалтын хөтөлбөрийн дагуу Төрийн байгууллага, албан хаагчдад харилцааны соёл, үйл ажиллагаандаа баримтлах дэг, жаягийг нийтлэг байдлаар танилцуулах, анхаарал хандуулах зарим асуудлаар танин мэдэхүйн болон практик мэдээлэл, зөвлөмж өгөх сургалтад 2023 оны 10 дугаар сарын 19-ний өдөр нийт албан хаагчид цахим хэлбэрээр хамрагдлаа.

- Нийслэлийн Хүний нөөцийн хөгжлийн төвөөс зохион байгуулсан "Хөгжлийн бодлогын баримт бичгийн төлөвлөлт, тайлагналт хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй" сургалтад 2023 оны 11 дүгээр сарын 13, 17, 21, 23-ны өдрүүдэд Архив бичиг хэрэг дотоод асуудал хариуцсан мэргэжилтэн Н.Нарангуа, Хяналтын инженер Б.Байгаль, Б.Батзориг, Нярав-Тоо бүртгэгч Б.Уянга, Хүний нөөцийн мэргэжилтэн Ц.Өсөхжаргал нар хамрагдаж гэрчилгээ авлаа.

- Нийслэлийн Хүний нөөцийн хөгжлийн төвөөс зохион байгуулсан "Төрийн албан хаагчийн ёс зүй, гадаад дүр төрх" сургалтад 2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр 5 Лифтийн механик хамрагдаж, мэдлэг чадвараа дээшлүүллээ.

- Барилга байгууламжийн чанар, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт, зөвлөгөөнд 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр хяналтын инженер Б.Батзориг, механик инженер Я.Батбаатар нар хамрагдлаа.

“Улаанбаатар лифт” НӨҮГ-ын 2023 оны үйл ажиллагааны жилийн эцсийн тайлан

- Нийслэлийн Архивын газар, “Ус сувгийн удирдах газар” ОНӨААТҮГ-тай хамтран “Архивын хадгаламжийн нэгж бүрдүүлэх, данс бүртгэл хөтлөх, архивын баримтын хадгалалт хамгаалалт” сэдэвт үзүүлэх сургалтад 2023 оны 12 дугаар сарын 08-ны өдөр Архив, бичиг хэрэг, дотоод асуудал хариуцсан мэргэжилтэн Н.Нарангуа хамрагдаж мэдлэг чадвараа дээшлүүлсэн.

3.3.2. Албан хаагчдын үйл ажиллагааны гүйцэтгэлд хяналт тавин, биелэлтийг тооцон холбогдох шагнал, урамшууллыг 4 ажилтанд олгуулсан.

3.3.3. Нийт ажилчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд жилд 1 удаа хамруулна. 2023 оны 4 дүгээр улиралд багтаан хамруулна.

Мөн Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны харьяа байгууллагуудын хоорондын уялдаа холбоог сайжруулах, хот нийтийн аж ахуйг сурталчлах, хамт олонч уур амьсгалыг бүрдүүлэх, багаар хамтарч ажиллах чадварт сургах, спортын талбарт шударгаар өрсөлдөх, ажилчдын эрүүл мэнд, биеийн хөгжил, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, дархлааг дэмжих зорилгоор “Шилжин явах цом”-ын төлөө 5 төрөлт тэмцээн 2023 оны 05 дугаар сарын 04-07-ны өдрүүдэд зохион байгуулагдсан ба байгууллага хамт олноороо идэвхтэй оролцсон.

- Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/327 дугаар захирамжийн хүрээнд “Улаанбаатар марафон-2023” олон улсын гүйлтэд 2023 оны 06 дугаар сарны 03-ны өдөр байгууллага хамт олноороо идэвхтэй оролцсон.

3.3.4. Ажлын сул орон тоог байгууллагын www.ublift.ub.gov.mn цахим хуудсанд байршуулж ил тод зарлан, сонгон шалгаруулж ажилд авч байна. 2023 онд зарын дагуу иргэдээс анкет болон ажилд орох хүсэлтээ ирүүлснээс Ахлах нягтлан бодогч-1, Жолооч-2 ажилтныг тус тус сонгон шалгаруулж ажилд авсан.

3.3.5. Ажилчдыг ажлын байранд тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Шагнал, урамшуулал, тэтгэмж олгох;
- Ажлын үр дүнг, гүйцэтгэлийн төлөвлөгөө, ажлын байрны тодорхойлолт болон хөдөлмөрийн гэрээтэй уялдуулан үнэн бодитой үнэлж, дүгнэх;
- Ажлын ачааллыг оновчтой хуваарилах;
- Ажиллах таатай орчныг бий болгох;
- Хамт олны дунд найрсаг уур амьсгалыг бүрдүүлэх;

3.4.Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлттэй холбоотой мэдээлэл

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын нэгдсэн систем erp.ulaanbaatar.mn нэгдсэн сайтаар хоёрдугаар улирлын байдлаар нийт 13 өргөдөл гомдол, хүсэлт ирсэн байна. Үүнд: ААНБ, СӨХ-ны үйл ажиллагаатай холбоотой 9 өргөдөл гомдол, байгууллагын ажилтнуудаас ирүүлсэн 4 хүсэлт ирснийг тухай бүр шуурхай шийдвэрлэн ажилласан байна.

Иргэд аж ахуйн нэгж байгууллагын хүсэлт, албан бичиг, өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн чанар, үр дүнг сайжруулж хуулийн хугацаанд нийслэлээс дэвшүүлсэн зорилтот түвшинд шийдвэрлэсэн байна.

/Манай байгууллага өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацааг 9 хоногт багтаан ажиллаж байна./

3.5. Байгууллагын 2023 онд гаргасан тайлан, мэдээ

Хүснэгт 2

№	2023 онд гаргасан тайлан, мэдээний нэр	Тайлагнасан хугацаа /сараар/												Тайланг хүргүүлсэн байгууллага	Гүйцэтгэлийн хувь
		1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12		
1	Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан ажил үйлчилгээний хэрэгжилт													НЗДТГ, УБЗАА	95%
2	Байгууллагын хагас, бүтэн жилийн үйл ажиллагааны тайлан													НЗДТГ, УБ хотын ЗАА	98%
4	Байгууллагын сарын үйл ажиллагааны тайлан, мэдээ, дараа сарын хийх ажлын төлөвлөгөө													Газрын даргын зөвлөл	100%
5	Байгууллагын дотоод хяналт шалгалтын төлөвлөгөөний биелэлт													Газрын даргын зөвлөл	100%
8	ХАСХОМ-ын тайлан													НЗДТГ	100%
9	Санхүүгийн тайлан													НСТСХ	100%
10	Нийгмийн даатгалын тайлан													БЗД-ийн НДХ	100%
11	Татварын тайлан													НТГ	100%
12	Үйл ажиллагааны болон нэмэлт санхүүжилт, дансны сарын мэдээ													НСТСХ	100%
13	Санхүүгийн үйл ажиллагааны мэдээ													Шилэн данс	100%
Дундаж хувь:														99%	

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. “БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ

4.1. Байгууллагын ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилттэй холбоотой мэдээлэл

Манай байгууллага цахим хуудсаараа дамжуулан байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээ мэдээллийг цаг алдалгүй түгээн хүргэдэг. Түүнчлэн Нийслэлийн эрх зүйн нэгдсэн сан болох www.ublegal.mn цахим хуудсанд байгууллагаас гаргасан захирамжлалын

“Улаанбаатар лифт” НӨҮГ-ын 2023 оны үйл ажиллагааны жилийн эцсийн тайлан

баримт бичгийг тухай бүр байршуулан цахим санг эрхэлж хөтлөх тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

“Улаанбаатар лифт” НӨҮГ нь нийслэлийн төсвөөс санхүүждэг тул бүх төлбөр тооцоо нь Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн хяналт дор хийгддэг. Нийслэлийн Өмчийн харилцааны газартай байгуулсан контракт гэрээний дагуу эд хогшил худалдан авах тохиолдолд саналаа өгч Нийслэлийн Өмчийн харилцааны газрын хурлаар шийдвэрлэгддэг ба мөн 10 сая төгрөгөөс дээш гэрээ хэлцлийг Нийслэлийн Өмчийн харилцааны газраас зөвшөөрөл авч байгуулдаг.

Санхүүгийн тооцооллын Acolous программыг ашиглан төсөв тооцоогоо гаргаж байна.

Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг Хүснэгт 3-т үзүүлэв.

Хүснэгт 3

№	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт	Хувь
Нэг. Үйл ажиллагааны ил тод байдал			
1	Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн, зохион байгуулалтын бүтцийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	2023 оны 04 дүгээр сард байгууллагын www.ublift.ub.gov.mn цахим хуудсанд байрлах танилцуулга, зорилго, зорилт, ажилтнуудын и-мэйл хаяг, харилцах утасны жагсаалт зэрэг мэдээллийг шинэчлэн байршуулсан. Цаг үеийн болон бусад 81 мэдээ, мэдээллийг тухай бүр байршуулан ажиллаж байна.	100%
2	Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Байгууллагаас үзүүлж буй үйлчилгээг хариуцан ажилладаг болон санал, хүсэлт хүлээн авах албан хаагчийн холбогдох мэдээллийг байгууллагын цахим хуудсанд байршуулж, өөрчлөлт орсон тохиолдолд тухай бүр шинэчлэн ажиллаж байна.	100%
3	Үйлчилгээ авахад шаардагдах бичиг баримтын жагсаалтыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Байгууллагаас үзүүлж буй ажил, үйлчилгээ авахад шаардагдах бичиг баримтын жагсаалтыг ublift.ub.gov.mn цахим хуудаснаа байршуулан тухай бүрт шинэчилж байна.	100%
4	Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа холбогдох 4 хууль тогтоомж, 1 дүрмийг цахим хуудас, мэдээллийн самбарт тогтмол байршуулж байна.	100%
5	Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг болон захиргааны хэм хэмжээний актын шийдвэрийн төслийг цахим хуудсанд 30-аас	Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг, захирамжлалын баримт бичгийн төслийг боловсруулахдаа холбогдох хууль тогтоомж, дүрэм, журамд үндэслэн	100%

“Улаанбаатар лифт” НӨҮГ-ын 2023 оны үйл ажиллагааны жилийн эцсийн тайлан

	доошгүй хоног ойлгомжтой байдлаар байрлуулж, холбогдох төрийн ба төрийн бус байгууллага, мэргэжлийн шинжээч, эрдэмтэн, иргэдийн саналыг авах, үндэслэлтэй гэж үзвэл уг саналыг төсөлд тусгах;	захиргааны шийдвэрийн төсөлд санал авах хуудсаар дамжуулан байгууллагын даргын зөвлөлийн гишүүдийн саналыг авч тусгадаг. Уг санал авах хуудаст тухайн шийдвэртэй холбоотой санал болон ашиг сонирхлын зөрчилтэй эсэх гэх мэт мэдээллийг багтаасан.	
6	Үзүүлж байгаа үйлчилгээний арга, хэлбэрийг боловсронгуй болгох зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх;	Лифтийг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрмийн технологийн дарааллын дагуу техникийн ээлжит магадлалыг хийж гүйцэтгэж байна. Техникийн ээлжит магадлалаар илэрсэн зөрчил дутагдлыг лифт ашиглагч байгууллага болон засвар, үйлчилгээг хариуцан ажилладаг механикаар тухай бүр арилгуулж, лифтний аюулгүй найдвартай ажиллагааг хангуулан ажилласан. Лифтийг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрмийн дагуу техникийн ээлжит магадлалын актыг үйлдэж, лифт ашиглагч байгууллагад хүргүүлэн ажиллаж байна.	100%
7	Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу төрийн байгууллагын гүйцэтгэх тодорхой чиг үүргийг төрийн бус байгууллага гүйцэтгэж байгаа тохиолдолд тухайн төрийн бус байгууллагын нэр, хаяг, цахим хуудас, эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэлийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлэх;	Байгууллагын гүйцэтгэх тодорхой чиг үүргийг төрийн бус байгууллага гүйцэтгэдэггүй болно.	-
8	Тухайн байгууллага тодорхой төрлийн аж ахуйн үйл ажиллагаа эсхүл бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгодог бол тухайн зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Манай байгууллага тодорхой төрлийн аж ахуйн үйл ажиллагаа болон бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгодоггүй болно.	-
9	Салбарын хэмжээнд улсын төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, явц, байдлын талаарх мэдээллийг цахим хуудсандаа байрлуулан тухай бүр шинэчлэх;	Жилийн эцсийн байдлаар байгууллагын www.ublifft.ub.gov.mn цахим хуудсанд үйл ажиллагаа, төсөв санхүү, хүний нөөцийн ил тод байдалтай холбоотой нийт 36 мэдээлэл, мэдээллийн самбарт дээд байгууллагаас ирүүлсэн тогтоол, захирамж, төсөв санхүү, хүний нөөцийн ил тод байдал, сахилга хариуцлага, ёс	100%

“Улаанбаатар лифт” НӨҮГ-ын 2023 оны үйл ажиллагааны жилийн эцсийн тайлан

		зүйтэй холбоотой 25 мэдээллийг тус тус байршуулсан. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн тухай бүр санхүүгийн мэдээллийг байршуулан ажиллалаа.	
Хэсгийн дундаж хувь:			100%
Хоёр. Хүний нөөцийн ил тод байдал			
10	Сул орон тооны зарыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх, энэ тухай олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах;	Ажлын сул орон тоог байгууллагын www.ublifit.ub.gov.mn цахим хуудсанд байршуулж ил тод зарлан, сонгон шалгаруулж ажилд авч байна. 2023 онд зарын дагуу иргэдээс анкет болон ажилд орох хүсэлтээ ирүүлснээс Ахлах нягтлан-1, Жолооч-2 ажилтныг сонгон шалгаруулж ажилд авсан.	100%
11	Албан хаагчийн ёс зүйн дүрмийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”, газрын даргын 2021 оны А/33 дугаар тушаалаар албан хаагчийн ёс зүйн дүрмийг шинэчлэн баталсан ба цахим хуудас болон мэдээллийн самбартаа тогтмол байршуулан ажиллагаандаа хэрэгжүүлэн, мөрдөж, зөрчил, дутагдалгүй ажиллаж байна.	100%
12	Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журмыг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Байгууллагын стратеги төлөвлөгөөнд үндэслэн “Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр 2021-2023 он”, “Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах дэд хөтөлбөр”-ийг боловсруулж Даргын 2021 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн А/12 дугаар тушаалаар баталсан. Энэхүү хөтөлбөрийг ажилчдын шуурхай зөвлөгөөнд дээр танилцуулж мэдээллийн самбарт байршуулсан. Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах 2023 оны төлөвлөгөөний хагас, бүтэн жилийн биелэлтийг гарган НЗДТГ-т хүргүүлсэн.	100%
13	Хүнийн өөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх;	“Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг 2023 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааг байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган, хэрэгжилтийг ханган ажиллалаа.	100%

“Улаанбаатар лифт” НӨҮГ-ын 2023 оны үйл ажиллагааны жилийн эцсийн тайлан

14	Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх;	Албан хаагчид хийж хэрэгжүүлэх үйл ажиллагаагаа сар, улирал жилийн хугацаатайгаар төлөвлөдөг ба гүйцэтгэл, үр дүнг ажилчдын шуурхай зөвлөгөөнөөр хэлэлцэн, дүгнэж ажилладаг. Ажилтнуудын ажлын гүйцэтгэлийг 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, ажлын байрны тодорхойлолт болон хөдөлмөрийн гэрээтэй уялдуулан дүгнэж байна.	100%
		Хэсгийн дундаж хувь:	100%
		Хэрэгжилтийн нийт дундаж хувь:	100%

ТАВДУГААР БҮЛЭГ. “БУСАД МЭДЭЭЛЭЛ”

5.1. Байгууллагын харьяа нэгжүүдийн үндсэн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ажилласан тухай мэдээлэл

Байгууллагын дотоод хяналтыг зохион байгуулах журмыг шинэчлэн боловсруулж даргын 2017 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн А/04 дугаар тушаалаар баталж мөрдөн ажиллаж байна. Байгууллагын “Дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах ажлын төлөвлөгөө”-г 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр байгууллагын даргаар батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

“Дотоод, хяналт шалгалтын ажлын төлөвлөгөө”-нд нийт 16 хийж хэрэгжүүлэх арга хэмжээ тусгагдсан ба хагас, бүтэн жилийн байдлаар төлөвлөгөөний хэрэгжилт 98 хувийн биелэлттэй байна. Хэрэгжүүлэх үйл ажиллагааг төлөвлөсөн хугацаанд нь хийж гүйцэтгэн үр дүнг тооцож, даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэн, хариу арга хэмжээг тухай бүр авч ажилласан. Түүнчлэн төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгаж байгаатай холбогдуулан байгууллагын хэмжээнд дотоод хяналтыг чангатган, тогтмол хяналт тавин ажиллаж байна.

Дотоод хяналт шалгалтын ажлын хагас, бүтэн жилийн тайлан мэдээг Газрын даргын зөвлөлд тайлагнасан.


5.2. Бусад үйл ажиллагаа

-Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн А/01 дүгээр тушаал болон 2023 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн “Ердөө 90 минут” их цэвэрлэгээний ажлын удирдамжийн дагуу байгууллагын гаднах орчны 50 метр хүртэлх талбай болон Бөхийн өргөөний уулзвараас зүүн тийш Зүүн 4-н замын уулзвар хүртэл замын урд талын явган замыг байгууллагын нийт ажилтнууд гудамж, зам талбайн хог хаягдал, цас мөсийг цэвэрлэсэн.

“Улаанбаатар лифт” НӨҮГ-ын 2023 оны үйл ажиллагааны жилийн эцсийн тайлан



- Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/94 дүгээр захирамжаар Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын цасны баяр, өвлийн биеийн тамир, спортын арга хэмжээний нээлтийг 2023 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 11.00-17.00 цагт Хандгайтын “Янзага” зусланд зохион байгуулагдсан бөгөөд манай байгууллагын 13 ажилтан оролцлоо.



- Байгууллагын хэмжээнд 2023 оны 02 дугаар сарын 17, 03 дугаар сарын 13, 07 дугаар сарын 03, 10 дугаар сарын 16, 11 дүгээр сарын 13-ны өдрүүдэд байгууллагын хаалга, цонх,

“Улаанбаатар лифт” НӨҮГ-ын 2023 оны үйл ажиллагааны жилийн эцсийн тайлан

фасадыг цэвэрлэх болон гаднах орчны 50 метр хүртэлх талбайг цэвэрлэх ажлыг зохион байгуулсан.



- Улаанбаатар хотын ерөнхий менежерийн 2023 оны 01 дүгээр тушаал, Баянзүрх дүүргийн засаг даргын 2023 оны А/147 дугаар тушаалаар батлагдсан хуваарийн дагуу 2023 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр байгууллагын хаалга, цонх, фасадыг цэвэрлэх болон гаднах орчны 50 метр хүртэлх талбайг цэвэрлэх ажлыг зохион байгуулж, нийт албан хаагчид идэвхтэй хамрагдлаа.



“Улаанбаатар лифт” НӨҮГ-ын 2023 оны үйл ажиллагааны жилийн эцсийн тайлан

- Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны харьяа байгууллагуудын хоорондын уялдаа холбоог сайжруулах, хот нийтийн аж ахуйг сурталчлах, хамт олонч уур амьсгалыг бүрдүүлэх, багаар хамтарч ажиллах чадварт сургах, спортын талбарт шударгаар өрсөлдөх, ажилчдын эрүүл мэнд, биеийн хөгжил, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, дархлааг дэмжих зорилгоор “Шилжин явах цом”-ын төлөө 5 төрөлт тэмцээн 2023 оны 05 дугаар сарын 04-07-ны өдрүүдэд зохион байгуулагдсан ба байгууллага хамт олноороо идэвхтэй оролцлоо.

- Сагсанбөмбөг
- Гарбөмбөг
- Дартс
- Ширээний теннис
- Шатарын тус тус тэмцээнд “Улаанбаатар шуурхай удирдлага зохицуулалтын төв” ОНӨТҮГ, “Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ хамтран оролцсон.



“Улаанбаатар лифт” НӨҮГ-ын 2023 оны үйл ажиллагааны жилийн эцсийн тайлан



- Монгол Улсын Ойн тухай хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 58 дугаар зарлигийн хүрээнд зохион байгуулагдаж буй “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, “Ногоон хот-Иргэний оролцоо” хаврын аянд нэгдэн 2022 онд “Ногоон хэрэм” төслийн талбай, “Айцын ам”-нд тарьсан моднуудыг 2023 оны 05 дугаар сарын 14-ний өдөр цэнэг усалгаа хийсэн.



- Нийслэлийн засаг даргын 2023 оны А/327 дугаар захирамжаар “Улаанбаатар марафон-2023” олон улсын гүйлтэд 2023 оны 06 дугаар сарны 03-ны өдөр байгууллага хамт олноороо идэвхтэй оролцлоо.

Байгууллагын албан хаагчдыг HI PAY application ашиглан марафонд бүртгүүлж, энгэрийн дугаараа авч, 5 километрийн “Эрүүл мэндийн гүйлт”-д байгууллагын албан хаагчдыг бүрэн хамруулж ажилласан.





- Байгууллагын гадна хашаан дахь мод, зүлгийг усалж, шарилжийг нь түүн ногоон байгууламжийг бүтээн ажилласан.



- Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн баталсан хуваарийн дагуу Бөхийн өргөөнөөс 84 дүгээр сургууль хүртэлх 550 м газрын явган хүний зам, байгууллагын ойр орчмын 50м газрын цас, мөсийг 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 11:00-15:00 цагийн хооронд цэвэрлэлээ.



“Улаанбаатар лифт” НӨҮГ-ын 2023 оны үйл ажиллагааны жилийн эцсийн тайлан

- Байгууллагын ойр орчмын 50м газрын цас цэвэрлэгээг батлагдсан хуваарийн дагуу 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 12:00 цагаас 15 цагийн хооронд зохион байгуулж, оролцлоо. Мөн Жуковын хөшөөнөөс БЗД-ийн уулзвар хүртэл голын ногоон байгууламжтай явган замыг Соёлын төв өргөө, Улаанбаатар спорт менежмент ХК-тай хамтран нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайн цас, мөсийг цэвэрлэж халтиргаа гулгаанаас сэргийлж ажилласан.



- Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөн зохион байгуулах 2023 оны хуваарийн дагуу 19 удаагийн ээлжит шуурхай зөвлөгөөнөөр Улаанбаатар хотын Захирагчаас өгсөн 65 үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь хүргүүлсэн. Дундаж хэрэгжилт 99 хувьтай байна.

ХЯНАЖ, ТАНИЛЦСАН
ДАРГА

ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН
ХҮНИЙ НӨӨЦИЙН
МЭРГЭЖИЛТЭН



Д.ТАН-ЭРДЭНЭ

Ц.ӨСӨХЖАРГАЛ